

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/17/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2026 он

Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер Э.Энхбаатар
Утас: 261885 Цахим хаяг: enkhbaatare@audit.gov.mn
Ахлах аудитор О.Баярмаа
Утас: 261740 Цахим хаяг: bayarmaao@audit.gov.mn
Аудитор Г.Сампилмаа
Утас: 261740 Цахим хаяг: sampilmaag@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
3.1. Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд...	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.5.1 Төсвийн төлөвлөлт	15
3.5.2 Төсвийн гүйцэтгэл.....	15
3.5.3 Нэмэлт төсөв	16
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	18
4.1 Ерөнхий зүйл	18
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	19
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.5.1 Завсрын аудитын талаар	19
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	20
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	21
5.1 Харьяа байгууллагууд.....	21
5.2 Төсвийн төвлөрүүлэн захирагч	21
5.2.1 Төлбөрийн акт.....	22
5.3 Түүврийн байгууллага.....	22
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	24

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БОУАӨЯ	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам
УЦУОШТ	Ус, цаг уур, орчны шинжилгээний төв
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ДАРГА Э.БАТТУЛГА ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.25 № 788
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Цаг уур, орчны шинжилгээний газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цаг уур, орчны шинжилгээний газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болон Бүгд Найрамдах Солонгос улсын Байгаль орчны яам, Байгаль орчны корпораци хоорондын гэрээ хэлэлцээрийн үр дүнд “Монгол улсад агаарын чанарын автомат станцыг байгуулж, агаарын чанарын менежментийн чадавхыг сайжруулах”-аар буцалтгүй тусламжаар нийслэл, 21 аймгийн төвд мэдээллийн технологид суурилсан орчны агаарын чанарыг хянах автомат станцыг суурилуулах, чадавхыг бэхжүүлэхэд зориулж нийт 8,914.7 мянган ам.долларын хөрөнгийг шийдвэрлэж, хэрэгжүүлсэн байна.

Монгол Улсын Засгийн газар болон НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр хамтран хэрэгжүүлсэн “Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавх болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь” (АДАПТ) төслийн хүрээнд ус цаг уур, орчны шинжилгээний салбарт 1,500.0 мянган ам.долларын үнэ бүхий шинэ үеийн супер компьютерын технологийг нэвтрүүлж, уур амьсгал, цаг агаарын тооцоолол, урьдчилсан мэдээний нарийвчлалыг сайжруулан, цаг агаарын гамшгийг эрт илрүүлэх, сэрэмжлүүлэх, урьдчилан мэдээлэх боломжийг нэмэгдүүлж, бэлэн байдлыг хангах, шуурхай хариу арга хэмжээ авах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Цаг уур, орчны шинжилгээний газрын инженерүүд нь цаг уурын автомат станцын мэдээг шуурхай хүлээн авах зорилго бүхий шөнийн хугацааны 23, 02, 05 цагийн мэдээг автоматаар хүний оролцоогүй кодолж, урьдчилан мэдээлэх шуурхай үйл ажиллагаанд ашиглах, олон улсын мэдээ солилцоонд гаргах "Overnight Weather Lookout" буюу "Шөнийн хугацааны цаг агаарыг ажиглагч" нэртэй программ хангамжийг бүтээж, үйлдвэрлэлд нэвтрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны А/237 дугаар тушаалаар "Цаг уурын салбарын орон нутаг дахь өртөөний байр"-ыг нийслэлийн 2 дүүрэг, 14 аймагт, нийт 20 өртөөг 5,624.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, тайлант онд барьж ашиглалтад оруулахаар 4 бүсээр багцлан эрх шилжүүлсэн боловч гүйцэтгэлээр 2 өртөөний 558.2 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон, хөрөнгө оруулалтын ажлын хэрэгжилт хангалтгүй байна.

Бусад асуудал

Төрийн аудитын байгууллага нь төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн аудитыг хийхдээ Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандартын дагуу хууль, тогтоомжийн хэрэгжилтэд нэмэлт горим сорил гүйцэтгэх үүрэг хүлээдэг.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



С.МАГНАЙСҮРЭН

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Дансны код	Тайлангийн үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	14,654,239.0	13,107,230.2
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	513,218.5	-
33	АВЛАГА	1,412,703.6	1,289,443.2
35	БАРАА МАТЕРИАЛ	12,728,316.9	11,817,787.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	47,451,353.0	49,264,958.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	47,451,353.0	49,264,958.0
39200	Биет хөрөнгө	37,180,133.8	39,030,982.2
39303	Биет бус хөрөнгө	10,271,219.2	10,233,975.8
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	62,105,592.0	62,372,188.2
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	62,764.2	397,160.6
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	62,764.2	397,160.6
41300	Өглөг	62,764.2	397,160.6
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	62,042,827.8	61,975,027.6
51	Засгийн газрын хувь оролцоо	62,042,827.8	61,975,027.6
51100	Засгийн газрын оруулсан капитал	26,787,837.5	26,787,837.5
51200	Хуримтлагдсан үр дүн	30,906,809.9	30,840,128.7
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,348,180.4	4,347,061.4
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	62,105,592.0	62,372,188.2

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Дансны код	Тайлангийн үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	95,615,344.7	85,634,304.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	13,772,585.2	85,634,304.7
120	Нийтлэг татварын бус орлого	13,772,585.2	7,700,740.2
122	Тусламжийн орлого	-	77,933,564.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	81,842,759.5	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	82,708,560.7	85,557,499.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	82,708,560.7	85,557,499.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	78,842,950.0	82,805,650.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	59,891,009.2	63,223,961.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,588,216.5	7,922,854.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,338,674.7	1,623,033.9
2104	Хангамж, бараа материалын зардал	896,242.1	1,425,838.7
2105	Нормативт зардал	89,511.0	68,102.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	731,392.3	606,051.7
2107	Томилолт, зочны зардал	326,551.4	269,890.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,571,478.8	1,020,772.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,409,874.0	6,645,145.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,865,610.7	2,751,849.5
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	12,906,784.0	76,805.2
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	5,382.9	-
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,164.4	106,771.3
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	4,218.5	(106,771.3)
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	12,911,002.5	(29,966.1)

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Дансны код	Тайлангийн үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	82,958,882.3	79,483,886.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	688,579.9	79,483,886.5
120	Нийтлэг татварын бус орлого	688,579.9	980,573.0
122	Тусламжийн орлого	-	78,503,313.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	82,270,302.4	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	79,243,773.4	79,782,567.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	79,243,773.4	79,782,567.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	74,807,583.6	75,860,160.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	60,000,334.0	63,291,070.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,550,691.6	7,917,769.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,345,064.8	1,631,538.2
2104	Хангамж, бараа материалын зардал	697,055.7	492,546.7
2105	Нормативт зардал	74,750.7	73,104.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,406,660.6	1,045,698.1
2107	Томилолт, зочны зардал	325,264.3	257,008.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,268,133.7	972,712.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	139,628.2	178,712.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,436,189.8	3,922,407.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	3,715,108.9	(298,681.2)
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	3,549,347.7	214,537.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,549,347.7	214,537.3
2200	Дотоод эх үүсвэрээр	3,549,347.7	214,537.3
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(3,549,347.7)	(214,537.3)
VII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	165,761.2	(513,218.5)
14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	347,457.3	513,218.5
15	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	513,218.5	-

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө /өмч
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	48,359,558.7		48,359,558.7
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	760,448.6		760,448.6
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	49,120,007.3	-	49,120,007.3
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	9,932.0		9,932.0
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	1,886.0		1,886.0
Тайлант үеийн үр дүн	12,911,002.5		12,911,002.5
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	62,042,827.8	-	62,042,827.8
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(36,715.2)		(36,715.2)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	62,006,112.6	-	62,006,112.6
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(1,118.9)		(1,118.9)
Тайлант үеийн үр дүн	(29,966.1)		(29,966.1)
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	61,975,027.6	-	61,975,027.6

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	76,394,452,700.00	75,148,470,065.39	1,245,982,634.61	98.4
Татварын бус орлого	76,394,452,700.00	75,148,470,065.39	1,245,982,634.61	98.4
Нийтлэг татварын бус орлого	205,378,000.00	950,299,146.28	(744,921,146.28)	462.7
Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	174,930,000.00	626,976,789.00	(452,046,789.00)	358.4
Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	30,448,000.00	323,322,357.28	(292,874,357.28)	1,061.9
Улсын төсвөөс санхүүжих	76,189,074,700.00	74,198,170,919.11	1,990,903,780.89	97.4
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	76,394,452,700.00	74,408,556,277.16	1,985,896,422.84	97.4
УРСГАЛ ЗАРДАЛ	76,394,452,700.00	74,408,556,277.16	1,985,896,422.84	97.4
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	74,194,202,100.00	72,575,280,923.51	1,618,921,176.49	97.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	62,363,091,100.00	61,389,639,282.94	973,451,817.06	98.4
Үндсэн цалин	30,118,367,100.00	29,978,921,434.33	139,445,665.67	99.5
Нэмэгдэл	21,461,928,600.00	21,212,539,837.45	249,388,762.55	98.8
Унаа хоолны хөнгөлөлт	5,832,647,800.00	5,866,265,417.36	(33,617,617.36)	100.6
Урамшуулал	4,613,147,600.00	4,331,912,593.80	281,235,006.20	93.9
Гэрээт ажлын хөлс	337,000,000.00	-	337,000,000.00	-
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх	7,777,884,500.00	7,686,049,673.19	91,834,826.81	98.8
Тэтгэврийн даатгал	5,284,307,800.00	5,221,326,124.15	62,981,675.85	98.8
Тэтгэмжийн даатгал	625,503,500.00	620,435,755.53	5,067,744.47	99.2
ҮОМШӨ-ний даатгал	316,689,600.00	314,131,929.70	2,557,670.30	99.2
Ажилгүйдлийн даатгал	311,378,300.00	308,015,712.13	3,362,587.87	98.9
Эрүүл мэндийн даатгал	1,240,005,300.00	1,222,140,151.68	17,865,148.32	98.6
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,640,677,200.00	1,609,626,292.69	31,050,907.31	98.1
Гэрэл, цахилгаан	806,125,100.00	784,137,779.87	21,987,320.13	97.3
Түлш, халаалт	743,091,900.00	736,770,208.11	6,321,691.89	99.1
Цэвэр, бохир ус	79,291,700.00	76,756,114.24	2,535,585.76	96.8
Байрны түрээс	12,168,500.00	11,962,190.47	206,309.53	98.3
Хангамж, бараа материалын зардал	368,221,800.00	283,458,534.32	84,763,265.68	77.0
Бичиг хэрэг	50,519,900.00	35,009,350.62	15,510,549.38	69.3
Тээвэр, шатахуун	94,331,600.00	93,883,902.00	447,698.00	99.5
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	136,175,400.00	94,119,489.70	42,055,910.30	69.1
Ном, хэвлэл	6,190,000.00	7,069,600.00	(879,600.00)	114.2
Хог хаягдал зайлуулах, устгал, ариутгал	15,041,000.00	7,630,317.00	7,410,683.00	50.7
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	65,963,900.00	45,745,875.00	20,218,025.00	69.3
Нормативт зардал	131,285,600.00	72,174,300.00	59,111,300.00	55.0
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	28,923,000.00	23,192,400.00	5,730,600.00	80.2
Нормын хувцас, зөөлөн эдлэл	102,362,600.00	48,981,900.00	53,380,700.00	47.9
Эд хогшил, урсгал засварын зардал	1,036,316,500.00	929,902,369.88	106,414,130.12	89.7
Багаж, техник, хэрэгсэл	744,875,400.00	673,851,889.88	71,023,510.12	90.5
Тавилга	2,400,000.00	2,395,250.00	4,750.00	99.8

Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	66,577,600.00	32,212,770.00	34,364,830.00	48.4
Урсгал засвар	222,463,500.00	221,442,460.00	1,021,040.00	99.5
Томилолт, зочны зардал	94,739,300.00	82,917,820.00	11,821,480.00	87.5
Дотоод албан томилолт	94,739,300.00	82,917,820.00	11,821,480.00	87.5
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	713,630,000.00	460,104,123.49	253,525,876.51	64.5
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	444,697,400.00	309,519,219.00	135,178,181.00	69.6
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	30,170,600.00	8,919,740.00	21,250,860.00	29.6
Даатгалын үйлчилгээ	25,161,000.00	3,765,104.00	21,395,896.00	15.0
Тээврийн хэрэгслийн татвар	7,288,100.00	5,553,302.50	1,734,797.50	76.2
Тээврийн хэрэгслийн оношилгоо	2,214,500.00	815,752.00	1,398,748.00	36.8
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	148,742,800.00	96,001,431.99	52,741,368.01	64.5
Газрын төлбөр	43,365,500.00	34,802,474.00	8,563,026.00	80.3
Банк, санхүүгийн байгууллагын үйлч/хураамж	6,045,900.00	-	6,045,900.00	-
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	5,944,200.00	727,100.00	5,217,100.00	12.2
Бараа үйлчилгээний бусад зардал	68,356,100.00	61,408,527.00	6,947,573.00	89.8
Бараа үйлчилгээний бусад зардал	20,148,400.00	15,148,375.00	5,000,025.00	75.2
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	48,207,700.00	46,260,152.00	1,947,548.00	96.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,200,250,600.00	1,833,275,353.65	366,975,246.35	83.3
Бусад урсгал шилжүүлэг	2,200,250,600.00	1,833,275,353.65	366,975,246.35	83.3
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	346,606,000.00	14,472,000.00	332,134,000.00	4.2
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,853,644,600.00	1,818,803,353.65	34,841,246.35	98.1
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	739,913,788.23	(739,913,788.23)	
БАЙГУУЛЛАГЫН ТОО	26	26	-	100.0
Төсвийн байгууллага	26	26	-	100.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	1722	1706	16	99.1
Удирдах ажилтан	63	56	7	88.9
Гүйцэтгэх ажилтан	1574	1578	(4)	100.3
Үйлчлэх ажилтан	85	72	13	84.7

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН		3,616,498,073.97
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		1,272,515,204.54
Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, Засгийн газар хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл		77,654,772.78
ЗГНС,ЗДНХ түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		1,479,727,253.70
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		382,359,169.71
Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		404,241,673.24
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		3,409,556,450.91
УРСГАЛ ЗАРДАЛ		3,398,723,770.91
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		3,395,523,770.91
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,901,430,901.83
Үндсэн цалин		146,818,590.95
Нэмэгдэл		1,448,917,176.19
Урамшуулал		305,695,134.69
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		231,719,967.94
Тэтгэврийн даатгал		190,641,933.22
Тэтгэмжийн даатгал		9,502,659.91
ҮОМШӨ-ний даатгал		9,194,370.47
Ажилгүйдлийн даатгал		2,607,850.80
Эрүүл мэндийн даатгал		19,773,153.54
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		21,911,877.06
Гэрэл, цахилгаан		11,768,595.06
Цэвэр, бохир ус		10,143,282.00
Хангамж, бараа материалын зардал		203,457,539.97
Бичиг хэрэг		10,079,620.00
Тээвэр, шатахуун		119,027,613.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		34,457,343.97
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		400,940.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		39,492,023.00
Нормативт зардал		930,000.00
Хоол, хүнс		730,000.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл		200,000.00
Эд хогшил, урсгал засварын зардал		289,100,289.11
Багаж, техник, хэрэгсэл		132,017,200.00
Тавилга		28,187,135.00
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		2,270,060.00
Урсгал засвар		126,625,894.11
Томиллолт, зочны зардал		174,090,787.00
Гадаад албан томиллолт		18,515,031.00
Дотоод албан томиллолт		155,575,756.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		513,608,558.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		504,771,602.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		800,000.00
Даатгалын үйлчилгээ		740,000.00
Тээврийн хэрэгслийн татвар		164,698.00

Тээврийн хэрэгслийн оношилгоо		112,500.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ		134,000.00
Газрын төлбөр		6,885,758.00
Бараа үйлчилгээний бусад зардал		59,273,850.00
Бараа үйлчилгээний бусад зардал		48,473,850.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		10,800,000.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		3,200,000.00
Бусад урсгал шилжүүлэг		3,200,000.00
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		200,000.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		3,000,000.00
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		10,832,680.00
Дотоод эх үүсвэрээр		10,832,680.00
Бусад хөрөнгө		10,832,680.00
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ		206,941,623.06

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Цаг уур, орчны шинжилгээний газар нь эрхэм зорилгоо “Ус, цаг агаар, байгаль орчны төлөв байдалд байнгын хяналт шинжилгээ хийж, бодит болон урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллээр нийгмийн хэрэгцээг шуурхай хангах, байгалийн болзошгүй гамшгийн эрсдэлээс сэрэмжлүүлэхэд оршино” гэж тодорхойлсон байна.

Тус газар нь ус цаг уур, орчны шинжилгээний улсын сүлжээний хөтөлбөрийн хэрэгжилт, тасралтгүй ажиллагааг хангах, мэдээллийн сан бүрдүүлэх, баяжуулах, тусгай хэрэгцээний мэдээгээр нийгэм эдийн засгийн салбаруудыг хангах, цаг агаарт зориудаар нөлөөлөх, ус, цаг уур, уур амьсгалын гаралтай аюултай болон гамшигт үзэгдлээс сэрэмжлүүлэх, орчны төлөв байдал, уур амьсгалын нөөц түүний өөрчлөлт, нөлөөллийн судалгаа хийх, тоон загварчлал, шинэ арга зүй, инноваци, технологи боловсруулах, үйлдвэрлэлд нэвтрүүлэх чиг үүрэг бүхий Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Цаг уур, орчны шинжилгээний салбарт Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль, Агаарын тухай хууль, Байгалийн ургамлын тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Усны тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Шилэн дансны тухай хуулийг үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэлд мөрддөг ба тэдгээрт томоохон өөрчлөлт гараагүй байна.

Цаг уур, орчны шинжилгээний газар нь үйл ажиллагааны стратегийн зорилт тус бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн дор дурдсан үйл ажиллагааны гол зорилтыг дэвшүүлэн, хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнд:

1. Богино, дунд, урт хугацааны урьдчилсан мэдээ, цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлийн сэрэмжлүүлэх мэдээллийг гаргаж, хэрэглэгчдэд шуурхай үйлчлэх;
2. Цаг уур, орчны шинжилгээний улсын сүлжээг мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах, сүлжээний техник, технологийн шинэчлэл, өргөтгөлийг төлөвлөж, хэрэгжүүлэх, дотоодын болон олон улсын мэдээ солилцооны хэвийн ажиллагаа, хэмжлийн технологи, стандартын нэгдмэл байдлыг хангах, цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаа, уур амьсгалын мэдээ, мэдээлэл, зөвлөмжөөр үйлчлэх ажлыг зохион байгуулах;
3. Салбарыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах, үйл ажиллагааны менежментийг боловсронгуй болгох, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, үйл ажиллагаанд дотоод хяналт тавих, шалгалт зохион байгуулах, санхүү, хөрөнгө оруулалтыг төлөвлөж хэрэгжүүлэх, хангамж, аж ахуйн үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах, төсвийн санхүүжилтийг үр ашигтай зарцуулах;
4. Хүрээлэн буй орчны чанарын төлөв байдлыг үнэлэх, мэргэжлийн дүгнэлт гаргах, орчны хяналт шинжилгээний үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах, хэмжил зүй, стандартын нэгдмэл байдлыг хангах, агаарын чанарын мэргэжлийн албаны үүргийг гүйцэтгэх;
5. Ус, цаг уур, орчны мэдээллийн төрийн архивыг эрхлэх, уур амьсгал, ус, цаг уур, орчны мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, мэдээний бүрэн бүтэн, нээлттэй байдал, хадгалалт хамгаалалтыг зохион байгуулах, хэрэглэгчдийг цахим болон цаасан суурьтай мэдээллээр үйлчлэх.

Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үнэллээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цаг уур, орчны шинжилгээний газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгээ холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлж, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан боловсруулсан байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Цаг уур, орчны шинжилгээний газрын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 266.6 төгрөгөөр буюу 0.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	513,218.5	-	(513,218.5)
Авлага	1,412,703.6	1,289,443.2	(123,260.4)
Бараа материал	12,728,316.9	11,817,787.0	(910,529.9)
Үндсэн хөрөнгө	47,451,353.0	49,264,958.0	1,813,605.0
Нийт хөрөнгийн дүн	62,105,592.0	62,372,188.2	266,596.2
Өр төлбөр	62,764.2	397,160.6	334,396.4
Засгийн газрын хувь оролцоо	62,042,827.8	61,975,027.6	(67,800.2)
Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн	62,105,592.0	62,372,188.2	266,596.2

Эх сурвалж: Цаг уур, орчны шинжилгээний газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн ахмадын сангийн 513.2 сая төгрөгийн үлдэгдлийг харьяа 12 байгууллагын ахмадын үйл ажиллагаанд зарцуулсан байна.

3.4.1 Авлага

Авлагын дансны үлдэгдэл 1,289.4 сая төгрөг болж, өмнөх оноос 123.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	10,465.0	30,914.3	20,449.3
Татаас, санхүүжилтийн авлага	569,749.0	37,601.6	(532,147.4)
Байгууллагаас авах авлага	815,991.7	1,203,890.6	387,898.9
Хувь хүмүүсээс авах авлага	16,497.9	17,036.7	538.8
Дүн	1,412,703.6	1,289,443.2	(123,260.4)

Эх сурвалж: Цаг уур, орчны шинжилгээний газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэл буурсан нь Ус, цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэнгийн “Засгийн газар хоорондын гэрээ болон олон улсын байгууллагаас хэрэгжүүлсэн төсөл”-ийн санхүүжилтийн 569.7 сая төгрөгийг оны эцэст төсөвт төвлөрүүлж, татаас санхүүжилтийн авлагыг барагдуулснаас шалтгаалжээ.

Сангийн сайдын 2026 оны 24 дүгээр тушаалын дагуу төсвийн байгууллагын 2025 оны төсвийн жилийн үйл ажиллагааны давсан орлогоос харьяа 23 байгууллагад нийт 716.6 сая төгрөгийг олгохоор хуваарилж, байгууллагаас авах авлагад бүртгэсэн байна.

3.4.2 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 11,817.9 сая төгрөг болж, өмнөх оноос 910.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Бараа материалын үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), бууралт
Түүхий эд материал	9,314,803.1	8,354,247.4	(960,575.7)
Дуусаагүй үйлдвэрлэл	21,206.1	21,206.1	-
Бэлэн бүтээгдэхүүн	1,940.0	893.0	(1,047.0)
Хангамжийн материал	3,346,637.7	3,399,967.9	53,330.2
Мал амьтад	43,710.0	41,472.6	(2,237.4)
Дүн	12,728,316.9	11,817,787.0	(910,529.9)

Эх сурвалж: Цаг уур, орчны шинжилгээний газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл буурахад харьяа 25 байгууллагад 3,247.9 сая төгрөгийн тусгай зориулалтын материал болон цаг агаарт зориудаар нөлөөлөх экспедицэд борооны пуужин олгосон нь голлон нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт:

- Дорноговь аймгийн УЦУОШТ: Бараа материалын дэлгэрэнгүй тайланд 12 нэр төрлийн 32 ширхэг нийт 332.8 сая төгрөгийн өртөгтэй үндсэн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн;
- Говьсүмбэр аймгийн УЦУОШТ: Аж ахуйн материал дансанд тухайн байгууллагын үйл ажиллагаанд хамааралгүй, ашигладаггүй, нийт 14.3 сая төгрөгийн 15 ширхэг зуух бүртгэлтэй;
- Дорнод аймгийн УЦУОШТ: Бараа материал нийлүүлэх гэрээний дүнгээс 0.6 сая төгрөгийн санхүүжилтийг илүү олгосон;
- Хөвсгөл аймгийн УЦУОШТ: Мал амьтдын дансанд ишиг 15.0 мянган төгрөг, 2-3 насны ямаа 15.0 мянган төгрөг, эр ямаа 40.0 мянган төгрөг, хурга 15.0 мянган төгрөг, 2 болон 3 настай хонь 15.0 мянган төгрөг, эр хонь 45.0 мянган төгрөг, нийт 7.8 сая төгрөгийн үнэлгээтэй ба зах зээлийн үнээс хэт доогуур үнэлсэн байна.

3.4.3 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 49,264.9 сая төгрөг болж, өмнөх оноос 1,813.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), бууралт (-)
Биет хөрөнгө	37,180,133.8	39,030,982.3	1,850,848.5
Барилга, байгууламж, орон сууц	20,137,562.6	19,698,207.0	(439,355.6)
Авто-тээврийн хэрэгсэл	1,645,953.2	1,886,025.8	240,072.6
Машин тоног төхөөрөмж (компьютер)	14,623,129.6	16,542,257.3	1,919,127.7
Тавилга, аж ахуйн эд хогшил	588,872.1	644,816.2	55,944.1
Бусад үндсэн хөрөнгө	184,616.3	259,676.0	75,059.7
Биет бус хөрөнгө	10,271,219.2	10,233,975.7	(37,243.5)
Програм хангамж	371,845.9	315,063.5	(56,782.4)
Бусад биет бус хөрөнгө	9,899,373.3	9,918,912.2	19,538.9
Дүн	47,451,353.0	49,264,958.0	1,813,605.0

Эх сурвалж: Цаг уур, орчны шинжилгээний газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өсөхөд ТӨБЗГ-ын 2025 оны 813 дугаар тогтоолоор Байгаль орчин хэмжил зүйн төв лабораторийн элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 123 нэрийн хөрөнгийн үнийг 2,502.1 сая төгрөгөөр шинэчлэн тогтоож, ашиглах хугацааг сунгасан нь голлон нөлөөлсөн байна.

Тайлант онд холбогдох тогтоол, шийдвэрийн дагуу үндсэн хөрөнгөд дараах томоохон өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

1. ТӨБЗГ-ын 2025 оны 432 дугаар тогтоолоор Цаг уур, орчны шинжилгээний газрын харьяа 12 байгууллагын элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 1198 нэрийн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт 881.7 сая төгрөгөөр үнийг шинэчлэн тогтоосон;

- ТӨБЗГ-ын 2025 оны 813 дугаар тогтоолоор Цаг уур, орчны шинжилгээний газрын харьяа 8 байгууллагын элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 753 нэрийн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт 2,924.3 сая төгрөгөөр үнийг шинэчлэн тогтоосон;
- ТӨБЗГ-ын 2025 оны 382 дугаар тогтоолоор БОУАӨЯ-аас 179.0 сая төгрөгийн балансын үнэ, 89.5 сая төгрөгийн үлдэх өртөгтэй хөрөнгийг балансаас баланст шилжүүлэн авсан;
- ТӨБЗГ-ын 2025 оны 457 дугаар тогтоолоор Цаг уур, орчны шинжилгээний газрын харьяа 16 байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, цаашид ашиглах боломжгүй 830 нэрийн 583.4 сая төгрөгийн балансын үнэтэй, үлдэх өртөггүй үндсэн хөрөнгийг акталж, данснаас хассан;
- ТӨБЗГ-ын 2025 оны 858 дугаар тогтоолоор Цаг уур, орчны шинжилгээний газрын харьяа 10 байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, цаашид ашиглах боломжгүй 288 нэрийн 301.6 сая төгрөгийн балансын үнэтэй хөрөнгийг акталж, данснаас хассан.

Аудитын илрүүлэлт:

- Баянхонгор аймгийн УЦУОШТ: Тус байгууллагын эзэмшлийн 13 газрын 46158 м.кв газрыг данс бүртгэлд тусгаагүй;
- Ховд аймгийн УЦУОШТ: Биет бус хөрөнгөд бүртгэлтэй ашиглахгүй байгаа эдийн засгийн үр өгөөж буурсан хөрөнгөд хяналт хэрэгжүүлээгүй;
- Архангай, Дундговь, Хөвсгөл аймгийн УЦУОШТ: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг актлах, дахин үнэлэх саналаа эрх бүхий байгууллагад хүргүүлж, шийдвэрлээгүй байна.

3.4.4 Өр төлбөр

Өр төлбөр дансны үлдэгдэл 397.2 сая төгрөг болж, өмнөх оноос 334.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Өр төлбөрийн дансны үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өглөг	61,958.0	3,333.5	(58,624.5)
Бараа үйлчилгээний зардлын өглөг	276.1	53,669.6	53,393.5
Байгууллагад төлөх өглөг	338.1	272,217.5	271,879.4
Хувь хүмүүст төлөх өглөг	192.0	67,940.0	67,748.0
Дүн	62,764.2	397,160.6	334,396.4

Эх сурвалж: Цаг уур, орчны шинжилгээний газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөрийн дансны үлдэгдэл өсөхөд тайлант онд эх үүсвэр дутагдсантай холбоотой Цаг уур, орчны шинжилгээний газрын зарим гэрээт ажлыг хугацаандаа гүйцэтгэж, хүлээлгэн өгсөн боловч санхүүжилтийг олгоогүй 196.4 сая төгрөгийн, харьяа 18 байгууллагын бусад байгууллагад өгөх 75.8 сая төгрөгийн, нийт 272.2 сая төгрөгийг олгоогүй нь голлон нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт:

- Булган аймгийн УЦУОШТ: Тайлант онд шуудан холбооны болон тээвэр шатахууны нийт 3.0 сая төгрөгийн байгууллагад төлөх өр төлбөр үүсгэсэн;
- Дорноговь аймгийн УЦУОШТ: Тайлант онд нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татвар, үйлдвэрчний эвлэлийн холбооны хураамжийн нийт 0.5 сая төгрөгийн өглөгийг тооцооны дансаар дамжуулалгүй, шууд зардалд бүртгэсэн байна.

3.4.5 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 61,975.0 сая төгрөг болж, өмнөх оноос 67.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 6. Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал	26,787,837.5	26,787,837.5	-
Хуримтлагдсан үр дүн	30,906,810.0	30,840,128.7	(66,681.3)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,348,180.3	4,347,061.4	(1,118.9)
Дүн	62,042,827.8	61,975,027.6	(67,800.2)

Эх сурвалж: Цаг уур, орчны шинжилгээний газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 61,975.0 сая төгрөг болж буурахад тайлант үеийн үр дүн 29.9 сая төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлжээ.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтөөр Ховд аймгийн Цаг уур, орчны шинжилгээний төвийн өмнөх оны элэгдлийн зөрүүг залруулж 36.7 сая төгрөгөөр өмнөх үеийн үр дүнг бууруулсан байна.

Биет бус хөрөнгө: Цаг уур, орчны шинжилгээний газрын программ хангамжид 2024 онд Ординат ХХК-аас тендер сонгон шалгаруулалтаар худалдан авсан “Unicus” албан ёсны лицензийн 22.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Цаг уур, орчны шинжилгээний газрын 2025 оны төсвийн төсөлд нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн 94,483.1 сая төгрөгийг улсын төсвөөс, 210.6 сая төгрөгийг төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр тооцож, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн саналыг хянан цалин хөлс, нэмэгдэл урамшууллын болон эд хогшил, урсгал засварын зардлыг 14.2 хувиар бууруулж 81,018.9 сая төгрөгөөр баталсан байна.

Тайлант оны тодотголоор цалин хөлс, нэмэгдэл урамшуулал болон нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 2,404.9 сая төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 1,741.0 сая төгрөгөөр, бусад зардлыг 1,150.9 сая төгрөгөөр тус тус бууруулан, бусад урсгал шилжүүлгийг 672.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж, төсвийг нийт 76,394.5 сая төгрөг болгон 5.7 хувиар бууруулж тодотгосон байна.

Төсөв захирагчийн тайлант онд хэрэгжүүлэх 7 хөтөлбөрийн 67 арга хэмжээний 76,394.5 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 74,198.2 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, төсөвт байгууллагын өөрийн орлогоор 950.3 сая төгрөгийг бүрдүүлж, бараа үйлчилгээний бусад зардалд 72,575.3 сая төгрөг, урсгал шилжүүлгийн зардалд 1,833.3 сая төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй 739.9 төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 74,408.6 сая төгрөг буюу 97.4 хувьтай байгаа нь бүтэц орон тооны хязгаарыг шинэчилж баталсны дагуу харьяа 26 байгууллага нь 171 орон тоог бууруулсантай холбоотой цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 973.5 сая төгрөгөөр, ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшууллын зардлыг 332.1 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсан байна.

Төрийн аудитын байгууллагаас Төсвийн тухай хуулийн дагуу хийх 2025-2026 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу судалгаа авч үр дүнг нэгтгэн дүгнэлээ. Үүнд:

Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын 2025 оны А/162 дугаар тушаалаар бүтэц орон тооны хязгаарыг шинэчилж баталсны дагуу бүтцэд өөрчлөлт оруулан, харьяа 26 байгууллага нийт 171 орон тоог бууруулсан байна.

Тус газрын харьяа 17 байгууллага эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулахад 13.2 сая төгрөг, зөвлөгөөний зардалд 10.2 сая төгрөг, нийт 23.4 сая төгрөгийг зарцуулсан байна.

Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой 312/ШШ2025/02194 дугаар шүүхийн шийдвэрээр ажлаас халагдсан 1 алба хаагчид Орхон аймгийн УЦУОШТ-ийн төсвөөс нийт 11.3 сая төгрөгийг олгож, буруутай шийдвэр гаргасан албан тушаалтнаар төлүүлэхээр авлага үүсгэн бүртгэсэн байна.

Цаг уур, орчны шинжилгээний газрын албан хаагчдад нийслэлд өдөрт хоолны хөнгөлөлт 15.0-34.0 мянган төгрөг, унааны хөнгөлөлт 3.0-10.0 мянган төгрөг, аймгийн төвд хоолны

хөнгөлөлт 10.0-20.0 мянган төгрөг, унааны хөнгөлөлт 3.0-15.0 мянган төгрөг, сумын төвд хоолны хөнгөлөлт 5.0-15.0 мянган төгрөгөөр тооцож, тайлант онд нийт 5,866.3 сая төгрөгийг унаа хоолны хөнгөлөлтөд зарцуулсан байна.

Цаг уур, орчны шинжилгээний газар болон БНСУ-ын цаг уурын газар хоорондын хамтын ажиллагааны уулзалт, хамтарсан судалгааны ажлаар 3 удаагийн гадаад томилолтын зардалд, төсвөөс 8.2 сая төгрөг, төслөөс 18.5 сая төгрөг, нийт 26.7 сая төгрөгийг зарцуулсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Төв аймгийн УЦУОШТ: Тайлант онд төсвийн төлөвлөгөөнд туслах үйл ажиллагааны орлогоос 0.07 сая төгрөгийн, жилийн батлагдсан төсвийн тодотголоор 0.1 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээр төлөвлөснөөс жилийн эцсийн байдлаар 22.7 сая төгрөгийн орлогыг бүрдүүлсэн ба орлогын төлөвлөгөөг тооцоо судалгаанд үндэслэхгүй, бодитой төлөвлөөгүй байна;
- Говь-Алтай аймгийн УЦУОШТ: Тайлант онд шилдэг ажилтан, албан хаагч шалгаруулж 8.2 сая төгрөгийн шагналыг цалингийн сангаас олгосон;
- Дорноговь аймгийн УЦУОШТ: Тайлант онд байгууллагын албан хаагчдын нэгдсэн сургалтыг Хилэнц ресортод зохион байгуулж, заалны түрээсийн төлбөрт 0.5 сая төгрөгийг зарцуулсан, мөн 6 ажилтанд цалинтай чөлөөтэй байх хугацаанд 1.2 сая төгрөгийн цалингийн нэмэгдлийг олгосон, 3 ажилтны 7.3 сая төгрөгийн цалинг нийгмийн даатгалын тайланд тусгаагүй;
- Өмнөговь аймгийн УЦУОШТ: Байгууллагын шилдэг ажилтнаар шалгарсан 4 албан хаагчид цалингийн сангаас 2.3 сая төгрөгийн шагналыг олгосон;
- Дорнод аймгийн УЦУОШТ: Цалинтай чөлөө олгосон албан хаагчдад 2.2 сая төгрөгийн цалингийн нэмэгдлийг, 0.07 сая төгрөгөөр амралтын цалинг тус тус илүү тооцож олгосон;
- Дундговь аймгийн УЦУОШТ: Сахилгын шийтгэлийн хугацаа дуусаагүй албан хаагчид улирлын үр дүнгийн мөнгөн урамшуулал 1.5 сая төгрөгийг олгосон;
- Говь-Сүмбэр аймгийн УЦУОШТ: : Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцан ажилласны нэмэгдлийн 1.4 сая төгрөгийг эрхгүй ажилтанд олгосон;
- Орхон аймгийн УЦУОШТ: Шуудан холбооны зардлаас 1.0 сая төгрөгийн түрээсийн төлбөрийг төлсөн;
- Хөвсгөл аймгийн УЦУОШТ: Байгууллагад ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээний дагуу олгосон 0.7 сая төгрөгийн ажлын хөлснөөс нийгмийн даатгалын шимтгэлийг суутган тооцож, төлөөгүй;
- Дархан-Уул аймгийн УЦУОШТ: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцан ажилласны нэмэгдлийг гүйцэтгэсэн ажил үүрэгт нь тохируулаагүй нийт 0.4 сая төгрөгийг илүү олгосон;
- Булган аймгийн УЦУОШТ: Цаг агаарт зориудаар нөлөөлөх үүл буудах экспедицийг хариуцан ажилласан инженерээс бусад 6 инженерт үндсэн цалингийн 10.0-20.0 хувиар тооцож, ажилласан хугацаанд ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг олгосон;
- Ховд аймгийн УЦУОШТ: Албан хаагчдын үндсэн цалинг нэмэгдүүлэхдээ ижил зэрэглэлтэй албан тушаалын үндсэн цалинг ялгаатай тогтоосон байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайланг гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар 3,616.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, 3,409.6 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 206.9 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлснээс 174.2 сая төгрөгийг буцаан авахаар дансны авлагад бүртгэсэн байна.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар нийт 3,616.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна. Тухайлбал:

- Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжаар 1,272.5 сая төгрөгийг;
- Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, Засгийн газар хоорондын гэрээгээр 77.7 сая төгрөгийг;

- ЗГНС, ЗДНХ түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан 1,479.7 сая төгрөгийг;
- Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан 382.4 сая төгрөгийг;
- Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 404.2 сая төгрөг.

Ус, цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэнд Засгийн газар хоорондын гэрээ болон олон улсын байгууллагаас хэрэгжүүлсэн төсөл, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, гадаадын их, дээд сургууль, хүрээлэн зэрэг 10 байгууллагаас авсан хандиваар 1,327.4 сая төгрөгийг, 1 төсвийн байгууллага болон 3 ТӨХХК-тай байгуулсан гэрээний дагуу 87.8 сая төгрөгийг, нийт 1,415.2 сая төгрөгийн орлогыг хүлээн авч, 1,241.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны А/237 дугаар тушаалаар “Цаг уурын салбарын орон нутаг дахь өртөөний байр”-ыг нийслэлийн 2 дүүрэг, 14 аймагт, нийт 20 өртөөг 5,624.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 2025 онд барьж ашиглалтад оруулахаар 4 бүсээр багцлан эрх шилжүүлж, гүйцэтгэлээр 2 өртөөний 558.2 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон, хөрөнгө оруулалтын ажлын хэрэгжилт хангалтгүй байна.

Мөн өмнөх оноос шилжих их засварын болон гадна засварын 3 төсөл, арга хэмжээний 204.2 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 05 дугаар “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай” албан даалгаврын 1.4.5-д “төрийн байгууллагын хэрэгжүүлдэг хөтөлбөр, арга хэмжээний зардлын санхүүжилтийг дараагийн төсвийн жилд шилжүүлэх” гэж заасны дагуу Цаг уурын салбарын орон нутаг дахь өртөөний байр барих 4 төсөл, арга хэмжээний санхүүжилтийн 2,031.4 сая төгрөгийг дараагийн төсвийн жилд шилжүүлэхээр хүсэлтээ илгээсэн байна.

Урсгал зардлаас Цаг уур, орчны шинжилгээний газрын 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нийт 2,245.9 сая төгрөгийн 14 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталснаас, гүйцэтгэлээр 10 төсөл, арга хэмжээний 885.9 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Цаг уур, орчны шинжилгээний газрын 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэл хангалтгүй гарахад эх үүсвэр дутагдалтай болон бусад шалтгааны улмаас 1,079.1 сая төгрөгийн 4 төсөл арга хэмжээг хэрэгжүүлээгүй нь голлон нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт:

- Өмнөговь аймгийн УЦУОШТ: Тайлант онд нягтлан бодогчийн хамаарал бүхий этгээд болох гэр бүлийн хүнээс 6.8 сая төгрөгийн нүүрс худалдан авч, 2.0 сая төгрөгийн урсгал засварын ажлыг гүйцэтгүүлсэн.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Цаг уур, орчны шинжилгээний газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, аудитаар баталгаажсан төсвийн захирагчийн жилийн эцсийн санхүүгийн тайлангийн дүнг өөрчилж, дараа оны эхний үлдэгдлээс зөрүүтэй тайлагнасан зөрчлийг давтан гаргахгүй байх, төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах зэрэг өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор О.Баярмаа, аудитор Г.Сампилмаа нар гүйцэтгэж, анхан шатны чанарын хяналтыг аудитын менежер Э.Энхбаатар, дараагийн шатны чанарын хяналтыг газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Цаг уур, орчны шинжилгээний газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 01/162 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан дахь сонгосон суурь үзүүлэлтээс 1.0 хувиар тооцож 827.1 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Юнивишн ХХК-тай нэмэлт гэрээ байгуулж дараах үйлчилгээг авч, зардлыг нийт 113.4 сая төгрөгөөр хэмнэсэн байна. Тухайлбал:

1. Агаарын чанарын автомат станцад ашиглаж байгаа 231 ширхэг гэр интернет дугаарын хугацааг 1 жилээр сунгаж, салбарын хэмжээнд жилд 110.9 сая төгрөгийг;
2. Автомат цаг уурын станцын 220 ширхэг дата дугаарын үйлчилгээг сунгаж 1.1 сая төгрөгийг;
3. Юнивишн ХХК-ийн шилэн кабелиг ашигласнаар өмнөх оноос зардал буурч 1.4 сая төгрөгийг тус тус хэмнэсэн байна.

Илрүүлэлт: Цаг уур, орчны шинжилгээний газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2012 онд үйлдвэрлэсэн, "Hyundai sonata" маркийн, 0895 УНУ улсын дугаартай автомашинд бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар аваагүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн автотээврийн хэрэгсэлд бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх авто тээврийн хэрэгсэлд бусдаас ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар аваагүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлсэн.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн зөрчилд 1 зөвлөмж өглөө.

Харьяа байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн нийцлийн аудитаар нийт 975.7 сая төгрөгийн 8 алдаа зөрчил илэрснээс зөрчлийг арилгах 1 албан шаардлага, 975.7 сая төгрөгийн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх 7 зөвлөмжийг өгсөн байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Түүврийн аудитад хамрагдсан зарим байгууллагын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй, нийт 861.3 сая төгрөгийн алдаа илэрсэн ба аудитын явцад засуулсан. Үүнд:

1. Улаанбаатар хотын Цаг уур, орчны шинжилгээний төв нь шилэн дансанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 157.5 сая төгрөгийн 9 гүйлгээ, зарлагын 182.8 сая төгрөгийн 6 гүйлгээ, нийт 340.3 сая төгрөгийн 4 гүйлгээг;
2. Цаг уур, орчны шинжилгээний газрын аппарат нь шилэн дансанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 215.9 сая төгрөгийн 9 гүйлгээ, зарлагын 76.0 сая төгрөгийн 9 гүйлгээ, нийт 291.9 сая төгрөгийн 18 гүйлгээг;
3. Нислэгийн цаг уурын төв нь шилэн дансанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 165.0 сая төгрөгийн 2 гүйлгээ, зарлагын 64.0 сая төгрөгийн 2 гүйлгээ, нийт 229.0 сая төгрөгийн 4 гүйлгээг тус тус шилэн дансны цахим хуудаст тус тус нөхөн байршуулсан.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих мэдээллийг хугацаанд нь иж бүрэн байршуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Аудитын илрүүлэлт:

- Дархан-Уул УЦУОШТ: Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хөрөнгө зарцуулах 3 шийдвэр, зарлагын 2 гүйлгээ, нийт 64.5 сая төгрөгийн 5 мэдээллийг байршуулаагүй;
- Баян-Өлгий аймгийн УЦУОШТ: Шилэн дансанд 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 35.6 сая төгрөгийн 9 гүйлгээг мэдээлээгүй;
- Өвөрхангай аймгийн УЦУОШТ: Шилэн дансны цахим хуудаст таван сая төгрөгөөс дээш орлогын 18 гүйлгээ, зарлагын 6 гүйлгээ, өмч хөрөнгө зарцуулсан 4 шийдвэрийг хугацаа хоцроож байршуулсан.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Шалгагдагч байгууллагын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийж гүйцэтгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн өмнөх аудитаар алдаа зөрчлийг арилгах 1,293.5 сая төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлснийг нотлох баримтад үндэслэн хэрэгжилтийг үнэлэхэд 85.0 хувьтай байна.

Хүснэгт 7. Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	793,358.3	1	793,358.3	90.0
Албан шаардлага /харьяа байгууллага/	1	500,185.3	1	500,185.3	80.0
Дүн	2	1,293,543.6	2	1,293,543.6	85.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар Ус, цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэнд хэрэгжүүлж байгаа “Засгийн газар хоорондын гэрээ болон олон улсын байгууллагаас хэрэгжүүлсэн төсөл, хамтарсан гэрээт ажил”-ын гүйцэтгэл, үр дүнг анхаарах нь зүйтэй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой нийт 1,300.7 сая төгрөгийн 25 алдаа¹ илэрснээс аудитын явцад 1,260.7 сая төгрөгийн 24 алдааг залруулж, 40.0 сая төгрөгийн алдааг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсөн байна.

Аудитаар нийт 620.4 сая төгрөгийн 35 зөрчил илэрснээс, 19.5 сая төгрөгийн зөрчилд 8 төлбөрийн акт тогтоож, 6.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах 8 албан шаардлага, албан тушаалтанд хариуцлага тооцуулах 12.5 сая төгрөгийн 1 албан шаардлагыг хүргүүлж, 582.1 сая төгрөгийн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх 16 зөвлөмж өгсөн байна.

Аудитаар илэрсэн 620.4 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшин 827.1 сая төгрөгөөс хэтрээгүй тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгөв.

5.1 Харьяа байгууллагууд

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 26 төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэснээс 15 байгууллагад бие даан дүгнэлт гаргаж, 11 байгууллагын санхүүгийн тайланг аудитын түүвэрт хамруулсан байна. Харьяа 15 байгууллагын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн байна.

Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар 1,096.4 сая төгрөгийн 56 алдаа зөрчил илэрснээс 488.7 сая төгрөгийн 22 алдааг аудитын явцад залруулж, 6.8 сая төгрөгийн зөрчилд 7 төлбөрийн акт тогтоож, 6.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах 8 албан шаардлага, албан тушаалтанд хариуцлага тооцуулах 12.5 сая төгрөгийн 1 албан шаардлагыг хүргүүлж, 582.1 сая төгрөгийн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх 18 зөвлөмжийг өгсөн байна.

5.2 Төсвийн төвлөрүүлэн захирагч

Аудитаар нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой нийт 811.9 сая төгрөгийн 3 алдаа илэрснээс аудитын явцад 771.9 сая төгрөгийн 2 алдааг залруулж, 40.0 сая төгрөгийн алдааг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

1.Цаг уур, орчны шинжилгээний газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг 768.8 сая төгрөгийн хасах үлдэгдэлтэй тайлагнасан. Үүнд:

- Санхүүгийн байдлын тайланд банкинд байгаа бэлэн мөнгө 259.6 сая төгрөг, ажиллагчидтай холбогдох өглөг 468.8 сая төгрөг, нийт 728.4 сая төгрөг;
- Санхүүгийн үр дүнгийн тайланд төвлөрүүлэх шилжүүлэг 17.3 сая төгрөг, их засвар 22.0 сая төгрөг, нийт 39.3 сая төгрөг;
- Өмчийн өөрчлөлтийн тайланд үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт 1.1 сая төгрөгийн хасах үлдэгдэлтэй.

2.Тайлант онд нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдлийн 2.4 сая төгрөг, төвлөрүүлэх шилжүүлгийн 0.7 сая төгрөг, нийт 3.1 сая төгрөгийн төсвийн тохируулга хийгээгүй байна.

Энэ нь УСНББОУС 24 “Санхүүгийн тайлан дахь төсвийн мэдээллийн толилуулгын дагуу байгууллага нь: Батлагдсан төсөв болон бодит гүйцэтгэл эдгээрийн зөрүүг тайлбарласан тохируулсан тайланг санхүүгийн тайлангийн бүрэлдэхүүнд тусгах ёстой” гэж заасныг мөрдөөгүй, Санхүүгийн тайлагналын “Иж бүрэн байх”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Илрүүлэлт: Аудитаар баталгаажуулсан Цаг уур, орчны шинжилгээний газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн жилийн эцсийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс 2025 оны эхний үлдэгдлийг 40.0 сая төгрөгийн зөрүүтэй тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл "Нягтлан бодох бүртгэлийн зарчим"-ийн 5.1.2-т "тасралтгүй байх", 5.1.4-т "үнэн зөв байх", 15 дугаар зүйлийн 15.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Аудитаар баталгаажсан төсвийн захирагчийн жилийн эцсийн санхүүгийн тайлангийн дүнг өөрчилж, дараа оны эхний үлдэгдлээс зөрүүтэй тайлагнасан зөрчлийг давтан гаргахгүй байх.

Аудитаар илэрсэн 12.6 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоосон.

5.2.1 Төлбөрийн акт

Өмнөх онд орон нутгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газруудын захиалагчийн хяналтын дүгнэлтийг үндэслэн баталгаажуулж дууссан ажлуудын зарцуулаагүй үлдэгдлийн 12.6 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх онуудад захиалагчийн хяналтын дүгнэлтийг үндэслэн баталгаажуулж дууссан ажлуудын зарцуулаагүй үлдэгдлийн 12.6 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

5.3 Түүврийн байгууллага

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа 4 байгууллагын санхүүгийн тайланд хийсэн түүврийн аудитаар нийт 49.8 төгрөгийн зөрчил илэрсэнд 2 зөвлөмж өглөө.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн хөрөнгийн зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу нэг эх үүсвэрээс худалдан авах аргаар сонгон шалгаруулсан Францын Модем компанитай байгуулсан гэрээний дагуу 1100 ширхэг М 20 төрлийн аэрологийн радиозондыг 2025.03.27-ны өдөр бүрэн хүлээн авсан боловч гэрээний нийт төлбөр 101,700.00 еврог 6 сард шилжүүлж, ханшийн өсөлттэй холбоотой батлагдсан төсвийг 15.6 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

2. Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Ус, цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэн нь төсвийн болон төслийн хөрөнгийн нийт 34.2 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна. Үүнд:

- Ус, цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэн болон НҮБ-ын Хүнс хөдөө аж ахуйн байгууллагын хооронд байгуулсан хамтын гэрээний дагуу "Монгол улсад уур амьсгалын өөрчлөлтийн ил тод байдлыг сайжруулах" (CBIT2) төслийн санхүүжилтээс үйл ажиллагаанд нь хамааралгүй Шангила ХХК-д зохион

байгуулсан "Үндэсний чуулган зохион байгуулах үйл ажиллагаа"-нд нийт 27.4 сая төгрөгийг зарцуулсан;

- Ус, цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэнгийн цайны зардалд төсвөөс 3.8 сая төгрөг, давсан орлогоос удирдах ажилтны зөвлөгөөний зардалд 2.3 сая төгрөг, төсвөөс 0.7 сая төгрөг, нийт 6.8 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.4-т "төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байх", 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах арга хэмжээг авч, зөрчлийг давтан гаргахгүй байх.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Шалгагдагч байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
А	Б	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
1	Булган аймгийн УЦУОШТ	3	3,908.1	3	3,908.1			3	3,908.1				
2	Говь-Алтай аймгийн УЦУОШТ	1	4,195.9			1	4,195.9	1	4,195.9				
3	Говь-Сүмбэр аймгийн УЦУОШТ	1	5,365.4	1	5,365.4			1	5,365.4				
4	Дорноговь аймгийн УЦУОШТ	1	2,308.7			1	2,308.7	1	2,308.7				
5	Дундговь аймгийн УЦУОШТ	1	1,502.0	1	1,502.0			1	1,502.0				
6	Төв аймгийн УЦУОШТ	2	127,383.4	1	38,022.3	1	89,361.1	2	127,383.4				
7	Увс аймгийн УЦУОШТ	2	1,339.3	2	1,339.3			2	1,339.3				
8	Сэлэнгэ аймгийн УЦУОШТ	1	100.6	1	100.6			1	100.6				
9	Сүхбаатар аймгийн УЦУОШТ	1	141,616.2			1	141,616.2	1	141,616.2				
10	Ховд аймгийн УЦУОШТ	4	164,054.7	1	37,851.1	3	126,203.6	4	164,054.7				
11	Хөвсгөл аймгийн УЦУОШТ	3	36,590.0			3	36,590.0	3	36,590.0				
12	Өмнөговь аймгийн УЦУОШТ	2	374.9			2	374.9	2	374.9				
13	Цаг уур, орчны шинжилгээний газрын нэгтгэсэн тайлан	3	811,939.2	1	40,000.0	2	771,939.2	2	771,939.2	1	40,000.0	1	40,000.0
	Дүн	25	1,300,678.4	11	128,088.8	14	1,172,589.6	24	1,260,678.4	1	40,000.0	1	40,000.0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Шалгагдагч байгууллагын нэр	Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл												
		Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Дүн	Тоо	Дүн
А	Б	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
1	Архангай аймгийн УЦУОШТ	1	-			1	-							
2	Булган аймгийн УЦУОШТ	2	5,260.5	1	919.9			1	4,340.6					
3	Баянхонгор аймгийн УЦУОШТ	2	966.2			2	966.2							
4	Говь-Алтай аймгийн УЦУОШТ	1	8,175.0					1	8,175.0					
5	Говь-Сүмбэр аймгийн УЦУОШТ	1	1,374.6			1	1,374.6							
6	Дархан-Уул УЦУОШТ	2	1,670.3	1	407.6	1	1,262.7							
7	Дорнод аймгийн УЦУОШТ	3	2,822.6	3	2,822.6									
8	Дорноговь аймгийн УЦУОШТ	5	341,810.7	1	1,229.5	1	460.0	3	340,121.2					
9	Дундговь аймгийн УЦУОШТ	2	57,764.2	1	1,496.6			1	56,267.6					
10	Төв аймгийн УЦУОШТ	1	22,698.8					1	22,698.8					
11	Орхон аймгийн УЦУОШТ	1	1,037.9					1	1,037.9					
12	Сэлэнгэ аймгийн УЦУОШТ	1	89,969.6					1	89,969.6					
13	Ховд аймгийн УЦУОШТ	2	925.0					2	925.0					
14	Хөвсгөл аймгийн УЦУОШТ	4	8,736.1					4	8,736.1					
15	Өмнөговь аймгийн УЦУОШТ	4	14,726.8			2	2,266.8	1	-	1	1	12,460.0		
16	Ус, цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэн	1	34,215.6					1	34,215.6					
17	Цаг уур, орчны шинжилгээний газар /ТШЗ/	1	15,600.0					1	15,600.0					
18	Цаг уур, орчны шинжилгээний газрын нэгтгэсэн тайлан	1	12,629.4	1	12,629.4									
	Дүн	35	620,383.3	8	19,505.6	8	6,330.3	18	582,087.4	1	1	12,460.0		

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Д/д	Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс			
		Тоо	Дүн	Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<i>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</i>							
1	Баян-Өлгий аймгийн УЦУОШТ	1	35,612.9			1	35,612.9
2	Дархан-уул аймгийн УЦУОШТ	1	64,480.6			1	64,480.6
3	Өвөрхангай аймгийн УЦУОШТ	1	-			1	-
4	Улаанбаатар хотын Цаг уур, орчны шинжилгээний төв	1	340,338.7			1	340,338.7
5	Цаг уур, орчны шинжилгээний газар ТШЗ	1	291,905.9			1	291,905.9
6	Нислэгийн цаг уурын төв	1	229,035.0			1	229,035.0
	Дүн	6	961,373.1			6	961,373.1
<i>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</i>							
1	Цаг уур, орчны шинжилгээний газар ТШЗ	1	-	1	-		
2	Говь-Сүмбэр аймгийн УЦУОШТ	1	14,250.0			1	14,250.0
	Дүн	2	14,250.0	1	-	1	14,250.0



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 204/АД160066

Улаанбаатар хот

САГ-2026/17/НА - СТА - ТТЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цаг уур, орчны шинжилгээний газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:


Өмнөх онуудад орон нутгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газруудын захиалагчийн хяналтын дүгнэлтийг үндэслэн баталгаажуулж дууссан хавсралтад дурдсан ажлуудын зарцуулаагүй үлдэгдэл 12,629,424.65 /арван хоёр сая зургаан зуун хорин есөн мянга дөрвөн зуун хорин дөрвөн төгрөг жаран таван мөнгө/ төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй, Төрийн сангийн барьцаа хөрөнгийн 100900013352 дугаар дансанд үлдэгдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2 дугаар зүйлийн 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Өмнөх онуудад захиалагчийн хяналтын дүгнэлтийг үндэслэн баталгаажуулж дууссан ажлуудын зарцуулаагүй үлдэгдэл 12,629,424.65 /арван хоёр сая зургаан зуун хорин есөн мянга дөрвөн зуун хорин дөрвөн төгрөг жаран таван мөнгө/ төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 10090000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга /Э.Баттулга/, ерөнхий нягтлан бодогч /Д.Жаргалсайхан/ нарт хариуцуулав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР
О.БАЯРМАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264290

9006102
ATA16087
9025081411

Z:\Akt\2026\0325_SAG-5.Docx

1526200277



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1073/А0160066

Улаанбаатар хот

САГ-2026/14/НА-СТА-ТТЗ

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цаг уур, орчны шинжилгээний газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цаг уур, орчны шинжилгээний газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2012 онд үйлдвэрлэсэн, "Hyundai sonata" маркийн, 0895 УНУ улсын дугаартай автомашинд бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар аваагүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн автотээврийн хэрэгсэлд бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй суудлын автомашинд бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар аваагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга /Э.Баттулга/, ерөнхий нягтлан бодогч /Д.Жаргалсайхан/ нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР
О.БАЯРМАА